



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2013 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 228

Улаанбаатар хот

Г Гүйцэтгэх захирлын албан тушаалд Г  
томилохыг зөвшөөрөхөөс татгалзах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Компанийн тухай хуулийн 81.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 10.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Хорооны улсын байцаагчаас захиргааны хэрэг бүртгэх ажиллагаа явуулж 2013 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 71 дүгээр “Зөрчлийн тухай тэмдэглэл” үйлдэж, №0037399 тоот тасалбараар захиргааны шийтгэл ногдуулсан болохыг тэмдэглэн, Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Хорооны улсын байцаагчийн хуульд заасан бүрэн эрхийн дагуу явуулсан захиргааны хэрэг бүртгэх ажиллагаагаар Туул овогтой Сайнбат нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн нь тогтоогдсон байх тул “Эм Жэй Ай Эйч” ХХК-ийн гүйцэтгэх захирлын албан тушаалд томилохыг зөвшөөрөхөөс татгалзсугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000395